



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/13

Улаан-Уул

Ажлын хэсэг томилж
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66,1 дэх заалт, сумын Онцгой комиссын 2022 оны 01 сарын 21-ний өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд хүн амыг “Ковид-19” цар тахлаас, мал амьтныг малын гоц халдварт шүлхий өвчний халдвар авахаас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглох, Монголын уламжлалт цагаан сар, сар шинийн баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан нийт ард иргэдэд цаг үеийн нөхцөл байдлын талаар сэрэмжлүүлэг өгөх, тандалт судалгаа хийх, иргэдийн санал хүсэлтийг сонсох, мэдээ мэдээллээр хангах ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд хариуцсан багуудад зохион байгуулахыг удирдлагын багийн ахлагч нарт үүрэг болгосугай.

2. “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаар мэдээ мэдээлэл, гарын авлагаар хангахыг Эрүүл мэндийн төвийн дарга (А.Сүхээ)-д, малын гоц халдварт шүлхий өвчний талаарх мэдээ мэдээлэл, мал аж ахуйн салбарт үзүүлэх эдийн засгийн хор хохирлын талаар гарын авлагаар хангахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (О.Намжирмаа)-д тус тус даалгасугай.

3. Шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын дарга (М.Зоригт), нягтлан бодогч (Ч.Батдорж) нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын хэсгийн тайланг илтгэх хуудсаар авч, нэгтгэж танилцуулахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ

643101185